



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/327

Ховд

Салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2, 9.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сурталчилах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: - Аймгийн Засаг даргын Дэд бүтэц, хөгжлийн бодлого хариуцсан орлогч

- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
 - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
 - Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
 - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
 - Эрүүл мэндийн газрын дарга

- Жаргалант сумын Засаг дарга
- Аймгийн Улаан загалмайн хорооны дарга
- Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын улсын байцаагч

- Ховд аймгийн Тээвэрчдийн холбооны гүйцэтгэх захирал

- Ховд АЗЗА төрийн өмчит улсын үйлдвэрийн газрын дарга

- Аймгийн автотээврийн төвийн дарга


- Албан журмын даатгагчдын холбооны Ховд салбарын менежер

- Нарийн бичгийн дарга:
 - Ховд аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн тогтоол, түүний хавсралтуудад заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, тайланг хагас, бүтэн жилээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын алба болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлж байхыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

3. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/626 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ